

Jesus Film Project®
A Cru Ministry

Knowing Jesus

# ЕСҮСИЙГ МЭДЭХ НЬ

Жижиг бүлэг ба Сайнмэдээ тараахад зориулсан гарын авлага

# Есүсийг мэдэх нь

Хувилбар 2.2

**Сайнмэдээ тараах бүлгийг шинээр тарих нь**

ЕСҮС киног ашиглан хүмүүст Есүсийг таниулж, тэднийг итгэлээр нь өсгөн дагалдуулж, улмаар итгэлийн бүлэг шинээр байгуулж, тэрхүү бүлгийг цааш нь өсгөн үржүүлэх адал явдалд та тавтай морил!

Эх хэлээрээ дамжуулан нутаг нэгтнүүддээ Хаанчлалаа байгуулахын тулд Бурхан таныг гайхалтай арга замаар ашиглахыг хүсдэг. Элч Иохан Илчлэл номд ийнхүү бичжээ:

***[9] Харагтун, үүний дараа намайг харахад, сэнтийн өмнө болон Хурганы өмнө зогсон, цагаан дээл өмссөн, гартаа далдуу модны найлзуур барьсан, үндэстэн бүрээс, бүх овгоос, бүх ард түмнээс, бүх хэлтнээс ирсэн үй олон хүн байв. Хэн ч тэднийг тоолж чадамгүй ажээ. [10]Тэд чанга дуугаар "Аврал бол сэнтийд залрагч бидний Бурханд ба Хурганд байдаг" гээд хашхирч байлаа. (Илчлэл 7:9-10 АБ2013)***

Энэхүү үйл олон хүмүүс нь дэлхийн бүх хэлтэн, бүх үндэстэн ястнаас ирсэн Эзэнд мөргөгчдөөс бүрдэх болно. Тэд төрөлх хэлээрээ, мөн өөр өөрийн ахуй соёлын онцлогийг илэрхийлэхүйц өвөрмөц хэлбэрээр мөргөл өргөж, магтан дуулцгаана.

Матайн сайнмэдээний номын сүүлийн эшлэлүүдэд Есүс ийн хэлсэн:

***[19] Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуулагтун, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа. [20] Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав. (Матай 28:19-20 АБ2013)***

Тэр бидэнд ЯВ, дагалдагч БЭЛТГЭ, тэдэнд БАПТИСМ ХҮРТЭЭ, ЗААЖ СУРГА гэж хэлсэн.

Түүний тушаалыг дуулгавартай дагаж, дагалдагчдыг өсгөж төлөвшүүлэх хамгийн тохиромжтой орчин бол итгэгчдээс бүрдсэн жижиг бүлэг буюу хамт олон юм.

"ЕСҮС" кино нь сайнмэдээ тунхаглахад маш тохиромжтой сайн хэрэгсэл юм. Та уг киног хөршүүд, гэр бүлийнхэн болон найзууддаа үзүүлж болох ба үр дүнд нь олон хүн Есүсийг дагахыг хүсэж, аврагдах болно.

Гэхдээ, та хайртай найзууд, гэр бүлийнхэндээ зөвхөн Есүсийн тухай яриад зогсохгүй цаашлаад тэднийг итгэхээр шийдэх үед нь "ЕСҮС" киноны 61 үзэгдлийг ашиглан Түүний амьдрал, сургаал, заасан сургаалт зүйрлэлүүд, үйлдсэн гайхамшгууд, мөн Түүний залбирал, зовлон, үхэл ба амиллын тухай үргэлжлүүлэн зааж итгэлээр өсөхөд нь туслаж болно.

# НЭГ ДЭХ АЛХАМ

# 01

**Та шинэ Сайн мэдээний бүлгээ хаана тарихыг хүсэж байна вэ? Есүсийн тухай мэдэх хэрэгцээтэй ойролцоох тосгон, хөрш суурин байгаа юу?**

Юуны түрүүнд та тухайн газраас "Амар тайвны хүн"-ийг олох хэрэгтэй. Лук 10:6-д Есүс өөрийг нь дагаж байсан 72 хүнд сургаалаа дайн илгээхдээ очсон газар бүртээ тэднийг хүлээн авах амар тайвны хүнийг хайж ол гэсэн байдаг. Тэр хүн нь тухайн газартаа нэр хүндтэйгээс гадна *ЕСҮС киног* үзүүлэхээр урих найз нөхөд, хамаатан садны хүрээлэл сайтай нэгэн байх юм.

Бид таныг тэр хүнтэйгээ харилцаа тогтоохдоо хялбархан цээжилж болох гурван алхмыг ашиглахыг зөвлөж байна. Энэ гурван алхам аяндаа таныг тэдэнд Есүсийн талаар ярих боломж руу дагуулах болно.

1. **Залбирал -** Амар тайвны хүний төлөө залбирна. Таныг найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ танилцуулж чадах хүнийг Бурхан танд харуулахын төлөө залбираарай. Тэгээд тэр хүнийг олж танилцсаныхаа дараа та түүний төлөө залбирмаар байгаагаа хэлж залбирлын сэдвийг нь асуугаарай. Хүмүүс тулгарсан асуудал, хэрэгцээнийх нь төлөө Есүсийн дагалдагч нар залбирч өгөхөд баярладаг. ЕСҮС киноны 25, 26-р үзэгдэлд Есүс залбирлын талаар заадаг.

2. **Халамж -** Шинэ найзынхаа төлөө залбирч түүний асуудал, хэрэгцээг ойлгосноор бид түүнийг анхааралтай сонсож, бодит хэрэгцээнүүдийг нь хангах замаар түүнд санаа тавьж буйгаа харуулж болох юм. ЕСҮС киноны 31-р үзэгдэлд Есүс Сайн Самари хүний түүхийг өгүүлэн хөршөө хэрхэн халамжилж санаа тавих талаар заадаг. Та ЕСҮС кинодоос Есүс маш олон удаа гайхамшиг үйлдэн хүмүүсийг ийнхүү халамжилж байсныг үзэж болно.

3. **Хуваалцах -** Хүмүүсийг сонсож тэдний хэрэгцээг нь хангаж туслах үед бидэнд Есүсийн сайнмэдээг хуваалцах боломж олддог. ЕСҮС киноны 33-р үзэгдэлд Есүс Закхайтай анд нөхөр бололцож, түүнд сайнмэдээг хуваалцаж байгаа түүх гардаг.

# ХОЁР ДАХЬ АЛХАМ 02

**“ЕСҮС” киног үзүүлнэ.**
“Амар тайвны хүн”-тэйгээ хамтран 20 юм уу түүнээс дээш тооны хүнийг урин “ЕСҮС” киногоо үзүүлээрэй. Энэ үйл ажиллагааг амартайвны хүнийхээ гэрт зохион байгуулсан ч болно. Магадгүй үүнээс ч олон хүн ирэх хүсэлтэй байж болох юм.

**Техник технологи хөгжсөн энэ эрин үед Есүс киног үзүүлж болох маш болон арга бий. Тэдгээрээс цөөн хэдийг нь энд дурдвал:**

1. Хэрэв танд Есүс Кино® үүргэвчтэй багц төхөөрөмж байгаа бол гадаа зохиогдох арга хэмжээний үед үүнийг ашиглан том дэлгэц тусган үзүүлж болно. Олон хүн ирж кино үзэхийг хүсэх болно.

2. Хэрэв танд USB оролттой нимгэн дэлгэцтэй LCD зурагт ашиглах боломж байгаа бол флаш диск ашиглан амартайвны хүнийхээ гэрт ЕСҮС киног үзүүлж болно.

3. Хэрэв танд блютүүд (bluetooth) чанга яригчтай таблетын багц төхөөрөмж байгаа бол ЕСҮС киног 20 хүртлэх тооны цөөн хүнд  үзүүлэх боломжтой.

Хүмүүс өөрсдийн төрөлх хэлээрээ Есүсийн түүхийг үзэж, сонсож байгаадаа сэтгэл догдлон баярлах болно!
Киногоо үзэж дуусаад үзэгчидтэйгээ дараа дахин холбогдохын тулд хоёр зүйлд урь.

Нэгдүгээрт, тэдэнд Есүс Христийг Аврагчаа болгон хүлээн авах боломж олго. (Олон хүн тэр дороо Есүсийг хүлээж авах болно!)

Хоёрдугаарт, тэднийг маргааш нь дахин ирж Есүсийн талаар илүү их ярилцахыг урь. Учир нь олон хүн сонирхож байгаа ч эхлээд асууж тодруулах зүйл ихтэй байдаг.

**Одоо хамгийн сайхан хэсэг дээрээ ирлээ!**

# ГУРАВ ДАХЬ АЛХАМ 03

## Сайн мэдээний шинэ бүлэг буюу жижиг бүлэг.

Киног үзсэн хүмүүс Есүсийг Аврагчаа болгон хүлээн авсан эсэхээс үл хамааран тэднийг Есүсийн талаар илүү ихийг ярилцахаар дараагийн өдрийн өдөр юмуу орой нь дахин ирэхийг урь. Та энэ уулзалтын үед, мөн дараа дараагийн уулзалтууд дээр ЕСҮС киноны 61 үзэгдлийг ашиглан Есүсийн талаар илүү гүнзгий суралцаж, Түүний талаар хамтдаа ярилцах юм.

Танай шинэ бүлэг ирэх нэг жилийн туршид Христийн дотор өссөөр байх болно. Тэд итгэлээр өсөх тусам бие биеэ илүү ихээр хайрладаг болж, тэрхүү хайраа өөрсдийн нийгэм хамт олонд түгээгээд зогсохгүй өөр бусад нийгэм хамт олонд хүргэснээр хайраа улам ихээр өсгө.

Шинэ бүлгийн гишүүд маань анхны уулзалтад ирсэн цагаасаа л Сайн мэдээний бүлгийн гишүүний амьдралыг амсаж эхэлдэг. Бид бүлгээр уулзах бүрдээ **“Гуравны гурав”**(3/3) гэж нэрлэгддэг аргыг ашиглана..

# Гуравны гурав

**Дагалдагч бэлтгэх сургалтын үйл явц**

**Эргэж харах**

- Бие биедээ санаа тавих. “Амьдрал чинь ямар байна даа?” гэж асуух.
- Магтаал хүндлэл
- Итгэмжтэй сайн үйлийг сайшаан тэмдэглэх
- Харилцан тайлагнах, давтлага
- Урам өгөх, зоригжуулах
- Алсын хараагаа сануулах

**Дээш харах**

- Шинэ хичээл
- Дуулгавартай байдалд суурилсан Библи судлал
- Хамтдаа Есүсийн талаарх шинэ түүхийг сурах

**Урагш харах**

- Үүрэг даалгавартаа бэлтгэх
- Түүхийг давтаж бататгах
- Бид энэ долоо хоногт хэнтэй хуваалцах вэ?
- Үүрэг зорилгынхоо төлөө залбирах

# ДӨРӨВ ДЭХ АЛХАМ 04

## Үржин олшир!

ЕСҮС киноны 17-р үзэгдэлд Есүс үр жимстэй амьдралын талаар заадаг. Энэ үед танай жижиг бүлэг өөр нэг шинэ бүлэг тарихаар НЭГ ДҮГЭЭР АЛХМаас дахин эхлэхэд бэлэн болсон байна!

Энэ үед тэд, Есүс муу сүнснээс илүү хүчтэй, байгалийг захирдаг, өвчтэйг эдгээж гэмийг уучлах эрх мэдэлтэй гэдгийг, мөн Есүсийг дагадаг хүний зан чанар ямар байх ёстойг, Есүс тэднийг үр жимсээр дүүрэн амьдрахыг хүсдэг гэдгийг аль хэдийн сурчихсан байх болно.

Та ч бас шинэ бүлгийг удирдах гол дагалдагчаа аль хэдийн тодорхойлчихсон байна байх. Түүнд шинэ бүлгээ 1-4 дүгээр алхмын дагуу эхлүүлэхэд нь туслаарай.

Бурхан таныг Өөрийн хаанчлалыг тэлэх агуу үйлсдээ ашиглана гэдэг итгэлийг тань Бурхан ерөөх болтугай хэмээн бид залбирах болно!

## “Есүсийг мэдэх нь” сургалтыг удирдах хоёр арга:

ЕСҮС киноны үзэгдлүүдийг ашиглан Сайн мэдээний шинэ бүлгээ хөтлөн явуулах энэ сургалтын хөтөлбөрийг та хоёр янзаар ашиглаж болно.

1. **Эхнээс нь дуустал хийх (1-р арга)** – ЕСҮС киног бүгдийг нь үзүүлсэний дараа (дээрх ХОЁР ДУГААР алхамд буй) Есүсийг танин мэдэх сургалтыг ашиглах эхний арга бол “ЕСҮС” киног үзсэн хүмүүсээс бүрдсэн бүлэг үүсгээд тэдэнд киноны үзэгдлүүдийг нэг нэгээр нь эхнээс нь дуустал дахин үзүүлэх юм. Энэ арга нь ЕСҮС кинонд агуулагддаг түүх болон сургаалуудыг бататган заахад маш тохиромжтой.

2. **Суурь тавих (2-р арга)** - Есүстэй танилцах сургалтыг ашиглах дараагийн арга нь гол гол үндсэн зарчмуудыг эхлээд судалснаар шинэ бүлгийн гишүүддээ итгэлийн сууриа илүү гүн тавихад нь туслах юм. Кампус Крусейд фор Крайст® нь (“ЕСҮС” киног бүтээсэн байгууллага) шинэ итгэгчдийг итгэлээр батжуулахад зориулж “Шилжин дамжих ухагдахуун” гэдэг нэртэй цуврал хичээлийг олон жилийн туршид боловсруулсаар ирсэн билээ. Эдгээр “Шилжин дамжих ухагдахуун”-уудыг ЕСҮС киноны янз бүрийн үзэгдлүүдээс харж болно.

Шилжин дамжих ухагдахууны бичгэн хувилбарыг Англи хэл дээр бүрэн эхээр нь дараах холбоосыг ашиглан цахимаар уншиж болно: **https://www.cru.org/us/en/train-and-grow/transferable-concepts.html.]** Мөн та дараах QR кодыг ашиглан цахим хуудас руу нэвтрэх боломжтой.

**Хэрэв та хоёр дахь аргыг ашиглаж байгаа бол эхлээд найман үзэгдлийг түүвэрлэн судлах хэрэгтэй болно.** (Дараагийн хуудсан дээр тэдгээр найман үзэгдлийг бүлгээр судлах дарааллынх нь дагуу жагсаасан болно.) Та эдгээр найман түүвэр үзэгдлүүдийг судалж дууссаныхаа дараа эргээд Есүстэй танилцах сургалтынхаа эхний хичээл рүү шилжнэ. Тэгээд эхнээс нь дуустал дарааллынх нь дагуу (яг 1 дүгээр аргын дагуу эхнээс нь хийж байгаа мэт) судална. Энэ тохиолдолд та дээрх найман хичээлийг хоёр дахин (давтлага маягаар) судална гэсэн үг.

## Суурь тавих (2 дахь) аргын үзэгдлүүдийн дараалал

**Үзэгдэл 61- "Яаж Христэд итгэгч болсоноо мэдэх вэ?"**
Та хэрэв өнөөдөр үхвэл мөнхийн улс руу явна гэдэгтээ ямар ч эргэлзээгүй итгэж байна уу? (Танд Зориулсан Гайхамшигт Төлөвлөгөө" бичлэгийг ашиглана.)

**Үзэгдэл 14- "Яаж Бурханы хайр ба уучлалыг мэдэх вэ?"**
Танд заримдаа Есүс Христийн дотор гэм нүгэл чинь бүрэн уучлагдсан гэдэгт итгэхэд бэрх санагддаг уу? Оюун бодлоороо үүнд итгэж байгаа ч сэтгэлийнхээ гүнд харин итгэж байна уу? ("Нүгэлт эмэгтэй уучлагдсан нь" бичлэгийг ашиглана.)

**Үзэгдэл 26- "Яаж Ариун Сүнсээр дүүрэн байх вэ?"**
Олон Христэд итгэгч нар Ариун Сүнсээр дүүрэн байх тухай хүчирхэг бөгөөд биднийг эрх чөлөөнд хүргэдэг мэдээг огт сонсоогүй байдаг. ("Залбирал ба итгэлийн тухай сургаал" бичлэгийг ашиглана.)

**Үзэгдэл 8- "Яаж үр жимстэй гэрчлэгч байх вэ?"**
Олон Христэд итгэгч нар тэд яагаад эргэн тойрных нь хүмүүс Христ рүү ирэхгүй байгаад гайхдаг. Гэвч бид хаана явсан газартаа Есүсийг үр нөлөөтэй гэрчлэх боломжтой. ("Гайхамшигтайгаар загас барьсан нь" бичлэгийг ашиглана.)

**Үзэгдэл 60- "Яаж Агуу Захирамжийн биелэлтэнд туслах вэ?"**
Сайнмэдээг бүх үндэстэнд хүргэх ёстой. Сайнмэдээний хүч ба хүмүүст Есүсийн талаар ярихын баяр жаргал. ("Агуу захирамж ба Тэнгэрт одсон нь" бичлэгийг ашиглана.)

**Үзэгдэл 31- "Яаж бусдыг итгэлээр хайрлах вэ?"**
Сайн Самари хүн нь бусдыг хайрлахад итгэл ямар чухал үүрэгтэйг харуулдаг. ("Сайн Самари хүний сургаалт зүйрлэл" бичлэгийг ашиглана.)

**Үзэгдэл 25- "Яаж итгэлтэйгээр залбирах вэ?"**
Танд орчлонгийн хамгийн хүчирхэг Нэгэнтэй шууд холбогдох эрх бий гэдгийг та бодож үзсэн үү? ("Эзэний заасан залбирал" бичлэгийг ашиглана.)

**Үзэгдэл 38- "Яаж баяр хөөртэйгөөр өгөх вэ?"**
Амьдралдаа туулж амсаж болох хамгийн сэтгэл хөдлөм адал явдлуудын нэг бол итгэлээр өргөх юм. ("Бэлэвсэн эмэгтэйн өргөл" бичлэгийг ашиглана.)

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна. (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой үйлдэл хийх

Дээш харах

## Танилцуулга

ЕСҮС киноны энэ үзэгдэл нь Бурхан газар дэлхий, ургамал, амьтан болон хүн төрөлхтөн гээд ертөнцийг бүхэлд нь бүтээсэн гэдгийг харуулдаг. Энэ хэсэгт Адам, Ева нар гэм нүгэл үйлдэж Бурханы эсрэг тэрсэлснийг мөн тэдний гэм нүглийн үр дагавар нь юу болохыг өгүүлнэ. Бурхан Абрахамд амлалт өгсөн бөгөөд дэлхийн гэмийг үүрэх Аврагчийг илгээнэ хэмээн амласан гэдгийг энэ хэсгээс сурах болно.

**Алхам 1:** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2:** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3**: Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4:** Ярилцах асуултууд

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Библи бүх зүйлсийг бүтээж буй түүхээр эхэлдэг. Бурханы төлөвлөгөөнд Дэлхий яагаад чухал үүрэгтэй вэ?
3. Бурхан ямар шалтгааны улмаас Адам, Ева хоёрыг бүтээсэн гэж Бичвэрт бичсэн бэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.



4. Адам, Ева хоёрт юу тохиолдсон бэ? Цэцэрлэгт байхдаа тэдний хийсэн зүйлийн үр дүнд юу болсон бэ?
5. Бурхан хүн төрөлхтөнд хайртай хэвээр байсан учраас тэднийг Өөртэйгөө дахин эвлэрүүлэх төлөвлөгөө Түүнд байсан. Абрахамын амьдралд тохиолдсон үйл явдал (энэ үзэгдэлд гарч байгаа) Бурханы төлөвлөгөөнд юу багтсаныг харуулсан бэ?
6. Бурханы хүмүүсийн гэм нүглийн төлөөх тахил болохоор хэн ирнэ гэж Бурхан амласан бэ?

## Дүгнэлт

Бурхан хүн төрөлхтөнийг Өөрийн дүр төрхийн дагуу, Түүнийг хайрлаж, Түүнтэй хамт сэтгэл хангалуун амьдрахаар бүтээсэн. Гэвч хүмүүс Бурханы эсрэг гэм үйлдсэн бөгөөд Түүнээс тусгаарлагдсан. Хүмүүсийг эргээд Өөртэйгөө харилцаатай болгох төлөвлөгөө Бурханд байлаа. Тэр төлөвлөгөөнийх нь нэг хэсэг бол амлагдсан Мессия буюу Есүс Христ бөгөөд Тэрээр гэмийн шийтгэлийг үүрэх ёстой.

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.

Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

Урагш харах

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархах.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна. (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Бүх хүнд төрсөн өдөр бий. Энэ амьдралд бүгд нэг л замаар ирдэг. Есүс ч мөн ялгаагүй. Есүс бол Бурханы Хүү бөгөөд Тэр бусдын л адил замаар энэ дэлхийд ирснээр хүн төрөлхтөнтэй ижилсэхийг сонгосон билээ.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Тэнгэр элч нар Марьд тэрээр Мессияг төрүүлэх болно гэж хэлэх үед Марь ямар хариу үзүүлсэн бэ?
3. Тэнгэр элч Габриел яагаад бяцхан хүүг Ариун Хүүхэд байх болно гэж хэлсэн бэ?
4. Есүс онгон эмэгтэйгээс төрсөн нь ямар ач холбогдолтой байсан гэж та бодож байна вэ?
5. Есүс Бэтлэхэмд төрөх нь ямар ач холбогдолтой байсан гэж та бодож байна вэ?(Мика 5:2-ыг унш)
6. Есүсийн төрөлттэй холбоотой олон үйл явдлуудыг туулахдаа Марь, Иосеф нар Бурханд хэрхэн итгэж байсан бэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Дүгнэлт

- Есүсийн зөвхөн төрөлт нь ч бус эхийн хэвлийд бүрэлдэх үйл явц нь ч онцгой байсан.
- Есүсийг төрөх үеийн туршид Марь, Иосеф хоёр Бурханд бүрэн итгэж байсан.
- Есүс онгон эмэгтэй Мариас төрсөн нь Түүнийг Бурхан хийгээд Хүн болохыг нотолдог.
- Бурханы Хүү Есүс дэлхийн сууриас ч өмнө, тэнгэр элч нар болон аливаа бүтээгдсэн бүхнээс өмнө Эцэгтэйгээ хамт оршин байсан билээ.

Урагш харах

## Хэрэгжүүлэх асуулт

Энэ үзэгдэл таны Есүсийн талаарх бодлыг өөрчилсөн үү? Хэрэв өөрчилсөн бол яаж өөрчилсөн бэ?

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархь.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна. (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Есүс хувь хүнийхээ хувьд хэрхэн өсөж төлөвших үл дуурайллыг бидэнд үлдээсэн. Библийн энэ хэсэгт Түүнийг эцэг эхдээ дуулгавартай байсан төдийгүй Бурханд дуулгавартай байж зан чанар нь төлөвшин Бурхан хийгээд хүмүүсийн таалллыг олж байсан гэж бичжээ. Бид амьдралынхаа туршид зан чанараа өсгөж төлөвшүүлсээр байх нь чухал гэдгийг мэдэж авах ёстой.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3**. Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Настай эр (Симон) Есүсийн талаар юу гэж хэлсэн бэ?
3. Есүс багш нарыг яаж гайхшруулсан бэ? Тэр үед ийм зүйл яагаад түгээмэл биш байсан бэ?
4. Библийн энэ хэсэгт Есүс Бурхан төдийгүй “төгс Хүн” гэдгийг хэрхэн харуулсан бэ?
5. Марь, Иосеф нар Есүсийг Хуучин гэрээнд заасан шашны ёс заншлын дагуу зөв өсгөн хүмүүжүүлж байгааг нь юунаас харж болох вэ?
6. Есүс Бурханы талаар ярихдаа ямар үг ашигласан бэ? Үүнээс үзвэл Тэр энэ насан дээрээ Өөрийнхөө талаар юу мэдэж байсан бэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Дүгнэлт

Иосеф, Марь нар Есүсийг өсгөн хүмүүжүүлэхдээ Бурханд дуулгавартай байж Түүнийг Дээгүүр өнгөрөх баярт дагуулж явсан. Тэд бидэнд үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх сайн үлгэр дуурайллыг харуулсан. Есүс дөнгөж 12 настайдаа л амьдралынхаа зорилгыг мэдэж байсан гэдгийг бид Библиэс харж байна. Бурхан Есүсийг хэрхэн өсөж торнисныг бидэнд харуулахын тулд Түүний хүүхэд насны талаарх энэ баримтыг тэмдэглэн үлдээжээ. Гэхдээ Түүний талаар бичигдсэн ихэнх зүйлс нь Бурханы бидэнд мэдүүлэхийг хүссэн Түүний насанд хүрсэн үеийн амьдрал ба үйлчлэлийн түүхүүд байдаг.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархх.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

# Үзэгдэл 4: “Есүс Иоханаас баптисм хүртсэн нь”

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна. (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Лук номын энэ хэсэг нь Есүсийн олон түмний дунд хийж буй үйлчлэлээр эхэлдэг. Есүс Иоханы баптисмийг хүртэх гэж Галилаас Иордан гол хүртэл алхаж ирсэн. Есүс Иоханаас баптисм хүртсэн нь гэмээс болж гашуудсаны илрэл биш байв. Яагаад гэвэл Тэр огт гэм нүгэл үйлдээгүй юм. Тэр Өөрийн амьдрал ба үхлийн аль алинд нь биднийг төлөөлж байгаагаа бүх дэлхийд харуулахын тулд баптисм хүртсэн аж.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Иохан хүмүүсийг “гэмших” ёстой гэж тунхаглахдаа яг юуны тухай ярьж байсан гэж та бодож байна вэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.



3. Есүс яагаад огт гэм үйлдээгүй атлаа баптисм хүртэхийг хүссэн гэж та бодож байна вэ?
4. Яагаад Бурхан Есүст “Чамд миний таалал оршдог” гэж тэнгэрээс айлдсан гэж та бодож байна вэ?
5. Бурхан хэдий цор ганц боловч гурвалаар оршдог гэдгийг Библи бидэнд заадаг. Үүнийг “Ариун Гурвал” гэж нэрлэдэг. Та Библийн энэ хэсгээс Ариун Гурвалын гурван гишүүнийг бүгдийг нь олж чадах уу? Тэднийг нэрлэнэ үү?
6. Есүсийн амьдралын зорилгын талаар Иохан юу хэлсэн бэ?

## Дүгнэлт

Есүст гэмшиж баптисм хүртэх ёстой нэг ч гэм байгаагүй. Тэр хүмүүстэй ижилсэхийн тулд л баптисм хүртсэн. Библи дээрх “гэмшил” гэдэг үг нь Есүсийн талаарх бодлоо өөрчилж шинэ амьдралаар амьдарна гэсэн утгыг илэрхийлдэг. Есүсийн үйлчлэлийн зорилго нь ертөнцийн гэмийг өөртөө үүрэхэд оршиж байсан гэдгийг бид эндээс сурч авлаа.

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

Урагш харах

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархах.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Есүсийг энэ дэлхийн бусад бүх хүнээс ялгаатай болгодог зүйл нь юу вэ? Түүний заасан сургаалууд уу? Түүний үйлдсэн гайхамшгууд уу? Мэдээж Есүсийг бусад бүх хүнээс ялгадаг зүйлсийн нэг бол Тэр огт гэмгүй Нэгэн байв. Түүний үг ба үйлдлийн алинд нь ч гэм байгаагүй. Диавол хүртэл Есүсээр гэм хийлгэх гэж оролдоод амжилт олоогүй юм. Диаволын талаар Шинэ Гэрээн дээр энд анх дурдсан байдаг. Хэрэв тэр Есүсээр гэм хийлгэж чадсан бол (яг Адам, Ева хоёроор гэм хийлгэсэнтэйгээ адил) хүн төрөлхтөнийг аврах Бурханы төлөвлөгөөг нураах байлаа.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.



2. Диавол Есүсийг ямар ямар аргаар сорьсон бэ?
3. Есүс соригдох үедээ диаволын эсрэг Библиэс иш татсан нь ямар ач холбогдолтой байсан бэ?
4. Есүс сорилтыг эсэргүүцэж чадсан нь Түүнийг Бурханы Хүү мөн гэдгийг яаж батлах вэ?
5. Есүс огт гэм нүгэлгүй байсан нь яагаад чухал гэж та бодож байна вэ?
6. Бидэнд сорилт тулгарах үед бид юу хийх ёстой вэ?

## Дүгнэлт

Есүс амьдралдаа нэг ч удаа гэм хийхгүй байснаар Өөрийгөө Бурханы Хүү мөн гэдгийг баталсан. Есүс тулгарсан сорилтыг эсэргүүцэхийн тулд Библиэс иш татсан. Диавол Есүсийг сульдаж ядарсан үед нь сорьсон. Диавол одоо ч хүмүүсийг амьдралын янз бүрийн талбарт сорьсоор байдаг. Энэ бүхний эцэст Есүс биднийг соригдох үед туслаж чадах юм.

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

Урагш харах

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархь.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Есүст хүн бүр өөр өөрөөр хариу үзүүлдэг. Зарим нь Түүний заасан сургаалуудыг хүлээн авдаг ч Түүний санал болгодог Авралыг хүлээн авдаггүй. Зарим нь Есүсийн талаар огт боддог ч үгүй. Харамсалтай нь Түүний төрөлх хот Назарын хүмүүстэй адил зарим хүмүүс Түүнийг үгүйсгэжээ.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүс Исаиа 61-р бүлгээс унших үедээ Өөрийнхөө талаар юу гэж хэлсэн бэ?
3. Энэ хэсэгт Есүс ядуус, сохор, олзлогдсон болон дарлагдсан хүмүүст санаа тавьдаг гэж бичсэн нь Есүсийн талаар юуг өгүүлж байна вэ?
4. 18-р эшлэлд Есүс “сайнмэдээ” гэдэг үгийг ямар утгаар ашигласан бэ? Библид өөр ямар үгийг “сайнмэдээ” гэдэг утгаар ашигладагийг та мэдэх үү?
5. Есүс 18-р эшлэлд “Эзэний Сүнс над дээр байна” гэж хэлсэн. Энэ хүртэл үзсэн хичээлүүд дунд Есүсийн амьдралд Ариун Сүнс ажиллаж байгаа өөр жишээ хаана гарсан бэ?
6. Тэдгээр хүмүүс яагаад Есүсийг хүлээж авахаас татгалзсан гэж та бодож байна вэ? Тэд Есүсийг хүлээж авахаас татгалзсан нь тэдний зүрх сэтгэлийн талаар юуг илэрхийлсэн бэ? Тэд Есүсийн эсрэг юу хийсэн бэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Дүгнэлт

Есүс Өөрийгөө Хуучин Гэрээнд амлагдсан Мессия гэдгийг илчилснээр ард олны дундах үйлчлэлээ эхэлсэн. Есүс хүмүүсийн бодит болон сүнслэг хэрэгцээнд аль алинд нь анхаарал тавьдаг. Бурхан хүмүүсийг Хүүд нь итгэж, ингэснээр гэмээс аврагдаж Түүний Хаанчлалд нэгдээсэй гэж хүсдэг.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархь.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

## Үзэгдэл 7: “Фарисай ба татвар хураагчийн сургаалт зүйрлэл” Лук 18:9- 14

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Хүмүүс ер нь яаж Бурхан руу ойртон очих вэ? Үндсэн хоёр арга зам бий. Нэг нь олон янзын хууль дүрмийг сахиснаар харин нөгөө нь итгэлээр. Христитгэлээс бусад бүх шашинд сүсэгтэн Бурханд таалагдахын тулд дуулгавартай дагах ёстой зүйлсийн жагсаалт буюу дүрэм гэж байдаг. Харин Христэд итгэх итгэл нь үүний эсрэгээр Бурханы тааллыг олохын тулд ямар нэг дүрэм сахин биелүүлэх хэрэггүй бөгөөд итгэлээрээ Бурхан руу ойртон очиж болно гэж үздэг цорын ганц итгэл үнэмшил юм. Христэд итгэгч нар Бурханы Христээр дамжуулан бидний төлөө хийсэн зүйл бол Бурхантай эвлэрэх цорын ганц зам гэж хүлээн авдаг. Энэ хэсэгт бид Израйлын шашны удирдагч бөгөөд хүмүүст Бурханы тухай заах үүрэг хүлээсэн “Фарисай” хүний талаар үзэх болно. Тэд маш олон дүрэм, хуулиудыг сахин биелүүлэх ёстой байлаа. Иймд тэд хүмүүсийг анхаарч санаа тавих үүргээ умартан өөрсдийгөө тэднээс илүү зөвт ариун гэж үздэг байжээ.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Израйлчууд татвар хураагчдад дургүй байлаа. Яагаад гэвэл тэд ард түмнийг дарангуйлагч Ромын засгийн газарт ажилладаг байсан бөгөөд ард түмнээс өндөр татвар авдаг байжээ.
3. Фарисай хүн ямар хандлагаар залбирсан бэ? Тэр яагаад бусад хүмүүсийг дорд үзсэн бэ?
4. Татвар хураагчийн хандлага ямар байсан бэ? Тэр Бурханаас юу гэж хүссэн бэ?
5. “Зөвтгөгдсөн” гэдэг үг ямар утгатай гэж та бодож байна вэ? (Ром 5:1-ийг үз)
6. Энэ түүхэнд гарч байгаа хоёр хүний аль нь Бурхантай эвлэрээд гэртээ харьсан гэж та бодож байна вэ? Яагаад?

## Дүгнэлт

Христитгэл нь хүнээс Бурхантай эвлэрэхийн тулд ямар нэг хууль дүрмийг сахихыг шаарддаггүй. Зөвхөн итгэлийг л шаарддаг. Бардам зан хүмүүсийг Бурханаас холдуулдаг. Яагаад гэвэл тийм хүмүүс Бурханд бус харин өөртөө итгэдэг. Хүмүүс даруу занг Бурханаас гуйвал Тэр тэдэнд өршөөлөө үзүүлж даруу болоход нь туслардаг.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурханы танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд таларх․
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга – Та үр жимстэй гэрч байхын тулд яах хэрэгтэй вэ?

Есүс дагалдагч нартаа Өөрийгөө Мессия гэдгийг мөн тэд Түүний дагалдагч болж “хүмүүсийн загасчин” болох ёстой гэдгийг мэдүүлэхийн тулд энэ гайхамшгийг үйлдсэн. Тэд Түүнийг Мессия мөн болохыг таньсан бөгөөд загасны тороо орхин Түүний дагасан. Энэ амьдралд хүмүүсийг загасчилахаас илүү сэтгэл хөдлөм, сүнслэг амьдралд ашиг тусаа өгдөг зүйл гэж үгүй. Та хэдийгээр өмнө нь хэнийг ч хэзээ ч Христ рүү дагуулж байгаагүй байж болох юм. Гэхдээ хэрэв Есүсийн удирдамжийг дагавал таны тор ч бас дүүрэх болно. Та Петр шиг эргэлзэж байж ч магадгүй. Гэхдээ хэрэв та ч бас дуулгавартай байвал Эзэн таныг ашиглан олон хүнийг Есүсийн дагалдагч болгох болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.



**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүс Петрийг юу хий гэсэн бэ? Энэ нь санал байсан уу эсвэл тушаал байсан уу? Энэ нь Есүсийн талаар юу өгүүлж байна вэ?
3. Есүсийн үгийг сонсоод Петр ямар хариу үзүүлсэн бэ?
4. Петр яагаад өөрийгөө “нүгэлт хүн” гэж хэлсэн бэ? Тэр ер бусын аргаар загас барьсныхаа дараа Есүсийг өөрөөсөө холдохыг хүссэн учир нь юу вэ?
5. Петр, Иаков, Иохан нар Есүсийг дагах шийдвэрээ хэрхэн илэрхийлсэн бэ?
6. Есүсийн хэлсэн та нар “хүмүүсийн загасчин” болно гэдэг үг ямар утгатай гэж та бодож байна вэ?
7. Таныг бусдад Есүсийн талаар ярихад юу саад болж болох вэ?
8. Есүс тэдэнд “Бүү ай.” гэж хэлсэн. Энэ гайхамшгийн нүдэн гэрч нар болж, Есүсийн хэлснийг сонссоны дараа ч дагалдагч нарыг айлгаж чадах зүйл юу байж болох вэ?

## Дүгнэлт

Үр жимстэй гэрч байхын тулд та Христэд итгэгч гэдгээсээ ичихгүй байхаас гадна танд гэмшээгүй гэм нүгэл байх ёсгүй. Та Ариун Сүнсээр дүүрэх ёстой. Эдгээрийг бид өмнөх хичээлүүд дээр хамт сурсан. Эцэст нь та сайн мэдээний түүхийг ойлгож аваад бусдад энэ итгэлээ хуваалцахад бэлэн байх ёстой. Та энэ түүхийг Есүсийн талаар мэдэх хэрэгтэй найзууд, хөршүүддээ өөрийн үгээр ярьж өгч болохоос гадна Есүс киноны сүүлийн үзэгдлийг үзүүлж болно. Хамгийн чухал нь та хүмүүсийг хайрлаж, тэдэн рүү ЯВЖ сайнмэдээг ЯРИХ санаачилгыг гаргах хэрэгтэй. Ийм боломж гарахын төлөө залбирч Бурхан таныг ашиглана гэдэгт найдан хүлээгээрэй.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

Өмнөх үзэгдлийнхтэй адилхан

## Залбирал

Өмнөх үзэгдлийнхтэй адилхан

## Үзэгдэл 9: “Иаирын охин эргэн амьдарсан нь” Лук 8:40-42, 49- 56

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Гашуудал бол хүн бүрт тохиолддог сэтгэл хөдлөл юм. Энэ түүхэнд аав нь өвчтэй байж байгаад нас барсан охиныхоо араас гашуудаж байгаа тухай гардаг. Тэр Есүсийг ирж охиных нь эдгээж өгөхийг хүссэн боловч одоо нэгэнт оройтжээ. Гэсэн хэдий ч Есүс түүнд бүү ай, гагцхүү итгэ гэж хэлсэн. Тэгээд Есүс охиныг нь үхлээс амьдруулснаар эцгийнх нь уй гашуу өндөрлөсөн. Биднийг гашуудаж байх үед Есүс бидний төлөө гайхамшиг үйлдэхгүй ч байж болно. Гэхдээ Тэр биднийг шаналан, гашуудах үед бидний сэтгэлийг тайтгаруулан эдгээж чаддаг нь гайхалтай хэрэг билээ.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Охинд нь туслахыг Иайр яагаад Есүсээс гуйсаар байсан бэ? Иайр Есүсийг хэн гэж хардаг байсан бэ?
3. Иаир охиноо нас барсныг мэдэх үед Есүс түүнд юу гэж хэлсэн бэ?
4. Есүс охиныг нас бараагүй харин унтаж байна гэх үед түүний эцэг эх хэрхэн хүлээж авсан бэ? Есүс яагаад ингэж хэлсэн юм бол?
5. Есүс үхсэн нэгнийг амьдруулж чадсан нь Түүний ямар чанарыг харуулж байна вэ?
6. Петр, Иохан, Иаков нар энэ гайхамшгийг хараад юу гэж бодсон бол?

## Дүгнэлт

Есүс үхсэн нэгнийг амьдруулж чаддаг нь Тэр бол Бурханы Хүү мөн гэсэн өөр нэг нотолгоо юм. Есүс гашуудаж буй хүмүүсийг өрөвдөн энэрдэг. Есүс биднийг үхэл ба хайртай хүмүүсээ алдахаас айх үед туслаж чадна. Биднийг зовж шаналж байх үед Есүс бидэнд туслаж чадна гэдэгт итгэхийг Тэр хүсдэг.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд таларх․
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Есүс анхнаасаа л үйлчлэлээ тусгайлан сонгогдож “элч нар” гэж нэрлэгдсэн дагалдагч нартаа өвлүүлэн үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байсан. Элч гэдэг үг нь “илгээгдсэн хүн” гэсэн утгатай. Хэрэв бид дагалдагчаа сонгосон бол магадгүй Түүнийхээс эсрэг сонголт хийх байсан байх. Харин Есүс боловсролгүй, хүнд хүчир ажил хийдэг, нийгэмдээ “нүгэлтэн” гэж тооцогддог төдийгүй зарим үед итгэлээр унаж, Түүнийг дагах шийдвэрээсээ ч хүртэл эргэж буцаж байсан хүмүүсийг сонгосон. Энэ нь хэн нэгэн Есүсийг дагахыг хүсэж л байгаа бол Есүс түүний хэн гэдгээс үл хамааран ашиглаж чадна гэдгийг харуулдаг.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүс арванхоёр дагалдагчаа сонгохоос өмнө бүхэл шөнөжин Бурханд залбирсны учир нь юу гэж та бодож байна вэ?
3. Эх орон нэгтнүүддээ үзэн ядагддаг татвар хураагч Матайг Есүс сонгосон. Эндээс Есүсийн талаар юуг харж болох вэ?
4. Матай яагаад мөнгө хураах товчооноосоо гарч Есүсийг дагасан гэж та бодож байна вэ? Матай Есүсийг дагахын тулд юунаас татгалзсан бэ?
5. Есүс Матайг дуудсаны дараа Матай яагаад Есүстэй уулзаж хамт оройн зоог бариулахаар бүх найзаа урьсан бэ?
6. “Элч” гэдэг үг нь “илгээгдсэн хүн” гэсэн утгатай. Энэ хүртэл сурсан зүйлс дээрээ үндэслэн харвал элч нар үйлчлэхээр явах үедээ түгээх ёстой мэдээ нь юу вэ?

## Дүгнэлт

Хэрэв Есүс залбирлыг ингэж чухалчилсан бол бид ч бас чухалчлах ёстой. Есүс эгэл жирийн тэр ч бүү хэл гэмтэй хүмүүсийг элчээрээ сонгосон. Есүс хүмүүсээр дамжуулан энэ дэлхий дээрх үйлчлэлээ үргэлжлүүлдэг. Есүс биднийг Матайн нэгэн адил Түүнийг хүмүүст танилцуулаасай гэж хүсдэг.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд таларх... 
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

## Үзэгдэл 11: “Ерөөлтэй хүний чанар” Лук 6:20-27

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Есүс хүмүүсийг Өөрт нь итгээд зогсохгүй Өөрийг нь дагаасай гэж хүсдэг. Бид Түүнийг дагаж, Түүний тушаалуудад дуулгавартай байх үедээ хамгийн амжилттай байж, ерөөгдөнө гэдгийг Тэр мэддэг. Лук номын энэ хэсэгт Есүс Түүний дагалдагч болохоосоо өмнө хүн өөрийнхөө талаар ямар бодолтой байх ёстойг тайлбарласан. Тэр Өөрийн дагалдагчдыг “ядуу” мөн “өлсөж буй” хүмүүс гэж дүрсэлсэн. Энэ хоёр үг нь Есүсийг Аврагчаар хүлээн авсан, Түүнийг Эзэн хэмээн дагахаар үүд хаалгаа нээсэн хүмүүсийн зүрх сэтгэлийн хандлага гэдгийг бид эндээс харах болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүсийн өгүүлсэн “сүнсэн дотроо ядуу” хүн гэдэг нь санхүүгийн хувьд ядуу гэхээсээ илүү сүнсэндээ ядуу нэгэн юм. “Сүнсэндээ ядуу” байна гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна вэ?
3. Мөн түүнчлэн Есүс “өлсөж буй” хүн гэж хэлэхдээ ходоод нь өлссөн гэх утгаар биш харин сүнсээр өлссөн хүний тухай ярьжээ. “Сүнсээр өлсөх” гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна вэ?
4. Христэд итгэдггүй хүмүүс итгэгч нарт дургүйцэн муу хандах үе гардаг. Христэд итгэгч нарт муугаар хандах үед итгэгч нар ямар хариу үзүүлэх хэрэгтэй вэ?
5. Есүс дагалдагч нараа хавчлага амсаж байгаа бол “ерөөлтэй еэ” гэж хэлсэн. Хавчлага зовлон эдэлж байгаа хүн яаж ерөөлтэй байж чадах вэ?
6. Яагаад энэ дэлхийн эд зүйлсээр баян хүн Есүст итгэх хэцүү байдаг вэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Дүгнэлт

Есүсийн дагалдагч байна гэдэг нь зүрх сэтгэлдээ даруу байна гэсэн үг. Есүсийн дагалдагч байна гэдэг нь Түүний тушаалуудыг дуулгавартай дагах үедээ амар тайван болон амьдралын утга учрыг олдог байна гэсэн үг. Есүсийн дагалдагч байна гэдэг нь танд муухай ханддаг хүмүүсийг уучилна гэсэн үг. Есүсийн дагалдагч байна гэдэг нь таны шагнал тэнгэрт байгаа гэдэгт итгэн тэнгэрийн улсыг харуулдан амьдарна гэсэн үг.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд таларх․
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**
- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**
- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**
- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**
- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Олон хүн Есүсийг хүндлэн биширдэг. Олон хүн Түүний сургаалуудыг магтан сайшаадаг. Олон хүн цуглаанд явдаг. Яагаад гэвэл Есүс тэднээс үүнийг л хийхийг хүсдэг гэж тэд боддог. Гэвч Есүс Түүнд хайртай, Түүнийг дагадаг хүмүүс Түүний хэлснийг хийдэг гэж хэлсэн. Ингэж хэлсэн учир нь хүмүүс Түүний сургаалуудыг нь дуулгавартай дагаж тэнгэрийн улсад ороосой гэсэндээ бус юм. Харин Тэр Түүнд дуулгавартай байхаар хичээж эрэлхийж байгаа хүмүүсийн амьдралыг ерөөж, бүрэн дүүрэн болгохын тулд ингэж хэлсэн юм. Есүсийн уулан дээр заасан сургаал нь Түүнийг дагаж, сургаалуудыг нь биелүүлэхийг хүсэгчдэд байвал зохих зан чанаруудыг тайлбарласан.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Хүмүүс яагаад баян болохыг хүсдэг гэж та бодож байна вэ? Есүс яагаад тийм их цагийг мөнгөний талаар ярихад зориулсан гэж та бодож байна вэ?
3. Есүсийн сургаалийг сонссон хүмүүс Түүнд ямар хариу үзүүлсэн бэ?
4. “Өршөөл” гэдэг үгийн утга юу вэ? Бурхан өршөөлөө хүмүүст хэрхэн илэрхийлдэг гэж та бодож байна вэ?
5. Яагаад таныг өвтгөж, зовоох зүйл хийсэн хүнийг уучлахад хэцүү байдаг вэ? Бурханы хувьд биднийг уучлах хэцүү болов уу?
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Петр яагаад Есүсийг таньдаг гэдгээ үгүйсгэсэн бэ?
3. Түүний энэ үгүйсгэлээс бид өөрсдийнхөө талаар юуг сурч болох вэ? Зүрх сэтгэл, сэтгэл хөдлөл болон хүсэл эрмэлзлийн хувьд?
4. Есүс Петр Түүнийг гурвантаа үгүйсгэнэ гэдгийг урьдаас хэлсэн. Энэ нь Есүсийн талаар юуг өгүүлж байна вэ?
5. Петр Есүсээс урвах байсан ч Есүс түүнийг голж орхиогүй. Эндээс бид Есүсийн талаар юуг сурч болох вэ? Эцэст нь Петр анхны чуулганы гол удирдагчдын нэг болсноос бид юуг ойлгож болох вэ?
6. Үзэгдэл 14 дээр “Сүнсний амьсгал”-ын талаар үзсэнээ эргээд сана. Энэ хичээл дээр гарч буй Петрийн нөхцөл байдалд тэр хичээлийг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

## Хэрэгжүүлэх асуулт

Та өмнө нь хийж байсан хамгийн муу үйлдлийнхээ талаар бодоорой. Таныг тийм зүйл хийснийг Есүс уучилна гэж та бодож байна уу? Хэрэв тийм бол яагаад? Хэрэв үгүй бол яагаад?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархал.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**
- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**
- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**
- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**
- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Лук номын энэ хэсэг Есүсийг Ромын болон Иудейн удирдагч нар доромжилж байгаагаар эхэлдэг. Хэдийгээр Есүс Өөрийгөө хамгаалуулж, авруулахаар түг түмэн тэнгэр элч нарыг дуудаж чадах байсан ч энэ бүхэнд даруугаар захирагдсан. Яагаад гэвэл энэ бол хүн төрөлхтөнийг аврах Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг байсан юм.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:
1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Яагаад Есүс энэ харгис хэрцгий хандлагыг зогсоохын тулд юу ч хийгээгүй вэ?
3. Харгалзагчид Есүст яаж хандсан бэ? Тэд яагаад Түүнд ингэж хандсан бэ?
4. Таны бодлоор, шашны удирдагч нар үнэхээр Есүсийг Мессия мөн эсэхийг мэдэхийг хүссэн үү? Тэд яагаад Есүсээс ингэж асуусан бэ?
5. Энэ хэсэгт Есүсийг хэд хэдэн янзаар тодорхойлсон. Тэдгээр нь тус бүртээ Есүсийн талаар юуг өгүүлж байна вэ?
6. Киноны энэ үзэгдлийн төгсгөлд шашны удирдагчид Есүсээс нэг зүйл асуусан. Есүс тэдэнд юу гэж хариулсан бэ? Энэ нь Түүний талаар юуг өгүүлж байна вэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Хэрэгжүүлэх асуулт

Таны амьдралд тохиолдож байсан зовлонтой хэцүү үеийг эргэн санаарай. Та тэр үед асуудалд яаж хандсан бэ? Ер нь зовлонг та яаж даван туулдаг вэ? Бурхан таны амссан зовлонгоос ямар нэг сайн үр дүнг бий болгож байсан жишээ байвал хуваалцана уу?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархх.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

# Үзэгдэл 47: “Есүсийг Пилат руу аваачив”

Лук 23:1-5

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Христэд итгэх итгэл нь улс төртэй огт хамаагүй. Гэхдээ дэлхийн өнцөг булан бүрт байдаг олон Христэд итгэгч нар зарим улс төрийн намуудыг итгэгчид бусад намуудаас илүү дэмжих нь зохистой гэж итгэдэг. Зуун зуун туршид хүмүүс улс төрийн янз бүрийн асуудлуудын талаарх өөрсдийн байр суурийг дэмжихэд Есүсийг ашиглах гэж оролдсоор ирсэн. Гэхдээ Есүс улс төрийн ашиг сонирхлын төлөө ирээгүй. Харин Тэр алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ. (Лук 19:10-ыг хар)

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Шашны удирдагчид яагаад Есүсийг Пилатад хүргэсэн бэ? Тэд Есүсийг юунд буруутгасан бэ?
3. Есүс улс төрийн зорилгоор хаан болно гэж мэдэгдэж байсан уу? Шашны удирдагч нар яагаад Пилатын өмнө Есүсийг ингэж гүтгэсэн бэ?
4. Есүсээс Түүнийг Бурханы Хүү мөн эсэхийг асуухад Тэр юу гэж хариулсан бэ? Тэр яагаад ингэж хариулсан бэ?
5. Энэ үзэгдлийн дунд хэсэгт Пилат Есүсийн талаар юу гэж дүгнэсэн бэ? Үүнд нь Иуйдейн удирдагч нар ямар хариу үзүүлсэн бэ?
6. Пилат яагаад Есүсийг Херод руу илгээхээр шийдсэн бэ? Энэ нь Пилатын зан чанарын талаар юуг илэрхийлж байна вэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Хэрэгжүүлэх асуулт

Есүс бидний амьдралыг захирахыг хүсдэг. Та Түүгээр амьдралаа бүрэн удирдуулж байгаа эсэхээ шударгаар дүгнэж хэлээрэй?
Бид бие биеэ Христийн удирдлага дор амьдралаа бүрэн захируулахад нь хэрхэн урамшуулах вэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархь.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**
- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**
- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**
- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**
- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга
Дээгүүр өнгөрөх баяр болж байсан тул Херод Иерусалимд байв. Тэр бол Есүсийн өссөн Назар хотын харъяалагддаг хойд Израйлын Галил аймгийн хаан юм. Херод зөвхөн Ромоос зөвшөөрсөн хүрээнд л захирдаг. Есүсийн үхэл ба амилалтын дараа Херод Христэд итгэгчдийг хавчдаг гол хүний нэг болсон бөгөөд хожим нь тэр элч Иаковыг цаазалсан. Херод хэдийгээр Есүсийн талаар сонсч байсан ч Пилат Есүсийг түүн рүү илгээх хүртэл Түүнтэй уулзаж байгаагүй аж. Херод бардам хүн байсан бөгөөд хожим нь Бурхан түүнийг хүмүүсээр шагшин магтуулж байх үед нь үхлээр цохьдог. (Үйлс 12:21-23)

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:
1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Херод яагаад Есүстэй уулзахыг хүссэн бэ? Херод Есүсээр өөртөө юу хийлгэхийг хүссэн бэ?
3. Яагаад зарим хүмүүс зөвхөн өөрийнхөө төлөө гайхамшиг үйлдүүлэхийн тулд л Есүстэй уулзахыг хүсдэг гэж та бодож байна вэ? Энэ нь тэдний зүрх сэтгэлийн талаар юуг илэрхийлж байна вэ?
4. Есүс яагаад Херодод хариулаагүй вэ?
5. Есүс асуултанд нь хариулаагүй тул Херод юу хийсэн бэ?
6. Яагаад Херод Есүсийг Пилат руу буцааж явуулсан бэ?

## Хэрэгжүүлэх асуулт
Та яагаад Есүсийг дагаж байгаа вэ? Үнэхээр Тэр Эзэн бөгөөд бүх алдар хүндлэлийг хүртэх зохистой учраас дагаж байна уу? Эсвэл Түүнийг таны төлөө ямар нэг зүйл хийж өгөхийг хүссэн учраас дагаж байна уу?
Та Бурханд таалагдахаас илүү хүмүүст таалагдаж хүлээн зөвшөөрөгдөхийг хүсч байсан үе байгаа юу? Жишээ байвал хуваалцана уу?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт
- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал
- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархх.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**
- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**
- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**
- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**
- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга
Заримдаа ойр тойрны хүмүүс маань биднийг тодорхой нэг зүйлийг хий гэж шахаж шаарддаг. Бид бусад хүмүүс юу гэж бодох бол гэсэн айдсаас болоод тэр дарамтанд автан зөв гэж итгэдэг зүйлээ хийж чадахгүйд хүрж болох юм. Тийм айдас нь биднийг жирийн үед хэзээ ч хийхгүй зүйлээ хийхэд, эсвэл хийх ёстой зүйлээ хийхгүйд хүргэдэг. Пилат ч бас ийм айдсын нөлөөгөөр Есүсийн талаарх шийдвэрээ гаргасан. Лук 23:20-д Пилат Есүсийг чөлөөлөхийг хүссэн гэжээ. Гэвч ард олон улам шаргуу шаардсанаас болоод тэр тэдний хүссэнээр шийдсэн.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:
1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүс буруутай эсэх дээр Пилат, Херод нар тус бүртээ ямар саналтай байсан бэ? Тэд дүгнэлтээ юунд үндэслэж гаргасан бэ?
3. Херод, Пилат хоёр яагаад Иудейн удирдагчдын Есүсийн эсрэг гаргасан буруутгалд итгээгүй вэ? Энэ нь Иудейн удирдагчдын талаар юуг өгүүлж байна вэ?
4. Пилат яагаад Иудейн удирдагч нар болон ард олонд Барабыг суллаж өгсөн бэ?
5. Пилат Есүсийг суллахыг хүсч байсан ч суллаагүй. Түүнийг Есүсийг цовдлох хүсэлтийг зөвшөөрөхөд хүргэсэн зүйл нь юу вэ? Пилатын сэтгэлд юу мэдрэгдэж байсан гэж та бодож байна вэ?
6. Есүс яагаад Пилатыг болон Иудейн удирдагчдыг зогсоох зүйл огт хийгээгүй вэ? (Матай 26:52- 54)

## Хэрэгжүүлэх асуулт
Ийм айдас танд яаж нөлөөлдөг вэ? Үүнтэй холбоотой жишээ байвал хуваалцана уу?
Та ер нь айдасаа яаж даван туулдаг вэ? Бурхан таныг айдаст автах үедээ юу хийгээсэй гэж хүсдэг гэж та бодож байна вэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт
- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэдний дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал
- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархал.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Энэ үзэгдэлд Есүс удахгүй Өөрийг нь хадах тэр загалмайг үүрэн явж буй нь гарна. Библийн энэ номыг бичсэн Лук Есүсийн олон хүн цугласан замаар үхэл рүүгээ алхаж байгаа төрхийг хэдхэн өдрийн өмнө Иерусалим руу “ялгуусан байдлаар орж ирсэн” төрхтэй нь харьцуулан харуулахыг зорьсон нь гарцаагүй.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Яагаад Есүс загалмайгаа Өөрөө үүрч явж чадахгүй байсан гэж та бодож байна вэ? Энэ нь Ромчууд түүнд яаж хандсаныг харуулж байна вэ?
3. Есүс загалмайгаа үүрч чадахаа болих үед Куреннй Симон гэгч эрд Түүний загалмайг үүрэхийг тушаасан. Симон Есүсийн загалмайг үүрээд явж байх үедээ юуг амсаж мэдэрсэн байх гэж та бодож байна вэ?
4. Есүсийг харж байсан эмэгтэйчүүд юу хийсэн бэ? Тэдний сэтгэлд нь юу мэдрэгдэж байсан гэж та бодож байна вэ?
5. Есүс яагаад эмэгтэйчүүдэд Түүний төлөө биш харин өөрсдийнхөө төлөө гашууд гэж хэлсэн бэ?
6. Энэ түүхэнд Христийн хайр хэрхэн илэрхийлэгдсэнийг та харж байна вэ?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Хэрэгжүүлэх асуулт

Таны бодлоор бие махбодын зовлон эдлэх эсвэл сэтгэлийн гүн зовлон эдлэх хоёрын алийг нь тэсвэрлэх илүү амархан бэ? Яагаад гэдгийг тайлбарлана уу? Библийн өөр нэг хэсэгт Куреннй Симоныг “Александр Руф нарын эцэг” гэж танилцуулсан байдгаас үзвэл энэ хүмүүсийг анхны чуулганыхан мэддэг байсан бололтой. Ихэнх теологчид энэ нь тэднийг Христэд итгэдэг болсон гэдгийг харуулж байна үздэг. Таны Есүсийг дагах амлалт шийдвэр танай гэр бүлийнхэнд ямар нөлөө үзүүлсэн бэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархах.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

## Үзэгдэл 51- 54: “Есүс цовдлогдсон нь”

**Лук 23:32- 43**

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

(**Энэ хичээлд ЕСҮС киноны Есүс цовдлогдсон нь, Цэргүүд Есүсийн хувцасны төлөө шодсон нь, Загалмай дээрх тэмдэг, Цовдлогдсон итгэгч* зэрэг үзэгдлүүдийг ашигласан)

Дээш харах

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

## Танилцуулга

Бусдыг уучлахад хэцүү үе байдаг. Хэн нэгэн биднийг өвтгөж шархлуулах үед бид шаналал, гашуудал, уур зарим тохиолдолд хорсол зэвүүцлийг мэдэрдэг. Шархалсан хүний төрөлх зөнгөөрөө хийдэг хариу үйлдэл бол өшөө авалт юм. Гэвч Есүс загалмай дээр байхдаа Өөрийг нь тэнд хадсан хүмүүсийг уучилсан. Үнэн хэрэгтээ, биднийг шархлуулсан хүмүүсийг уучлах нь бидэнд эрх чөлөөг өгдөг. Уучиллын үр дүнд бид бусдын сөрөг нөлөөнд автахаа больж, Бурхантай эвлэрдэг. Есүсийн үлгэр дуурайллыг дагацгаая!

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.

**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүсийн загалмай дээр хэлсэн эхний үг нь уучлалын тухай байсан. Есүс энд хэний тухай ярьсан бэ? Энэ нь Христийн хайрын талаар юуг илэрхийлж байна вэ?
3. Хүмүүс “Тэр бусдыг аварсан одоо Өөрийгөө авраг.” гэж хэлсэн нь ямар утгатай гэж та бодож байна вэ? Хэрэв Есүс тэр үед загалмайнаасаа бууж ирсэн бол тэд Түүнд итгэх байсан уу? Яагаад тийм эсвэл үгүй гэж хариулснаа тайлбарлана уу?
4. Гэмт хэрэгтэн Есүсээс “Та Өөрийн хаанчлалд очихдоо намайг санаарай.” гэж хүссэн нь ямар утгатай вэ?
5. Есүст итгэх итгэлээ илэрхийлсэн гэмт хэрэгтэнд тохиолдсон зүйл хожим Есүс руу ирэх бүх хүний талаар юуг харуулж байна вэ?
6. Энэ бүхнийг харж байсан хүмүүс Есүс Өөрийгөө Мессия хэмээн тунхаглаж байсныг ойлгосон. Түүнийг загалмай дээр байгааг харсан хүмүүс юу гэж бодож байсан гэж та бодож байна вэ?

## Хэрэгжүүлэх асуулт

Танд бусдыг уучлах хэцүү байдаг уу? Таныг яаж гомдоож, шархлуулсан хүнийг уучлах илүү хэцүү байдаг вэ?
Есүсийн харуулсан уучлалын жишээ танд ямар нөлөө үзүүлж чадах вэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархах.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Хуучин гэрээнд Израйл үндэстэн Бурхантай уулзахын тулд Ариун сүмд очдог байсан. Сүм бол тэдний тахилаа авчирж өргөн, хамтдаа Бурханд мөргөдөг газар нь байв. Жилд нэг удаа “Ахлах тахилч” (бусад бүх тахилчдын дээрх тахилч) “Ариунаас ариун газар” гэж нэрлэдэг Сүмийн дотоод танхимд орж тусгай тахилыг өргөдөг байжээ. Энэ тахилыг хүмүүсийн нүглийг “наминчлах” (нөхөн төлөөс)-ын тулд өргөдөг байв. Ариунаас ариун газрыг асар том хөшгөөр сүмийн бусад хэсгээс тусгаарладаг байжээ. Өнөөдрийн үзэгдэл дээр тэр хөшиг Есүсийг үхэх үед хоёр хэсэгт хуваагдан урагдаж байгааг харна. Энэ нь одоо Бурхан руу хүрэх ганц зам бол зөвхөн Есүсийн үхэл бөгөөд өөр ямар ч тахилчийн өргөх тахил хэрэггүй гэдгийг харуулсан.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.



**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүсийг нас барахын өмнөх гурван цагийн турш тэр газарт харанхуй нөмөрсөн. Энэ харанхуй юуг бэлгэдсэн гэж та бодож байна вэ?
3. Есүс “Аавaa Би сүнсээ Таны гарт даатгая” гэж хэлсэн нь юуг онцлон илэрхийлсэн гэж та бодож байна вэ?
4. Есүсийг харж байсан хүмүүс ямар хариу үзүүлсэн бэ?
5. Есүсийн нас барахыг харж байсан зуутын дарга юу гэж хэлсэн бэ? Түүнийг Есүст итгэсэн байх гэж та бодож байна уу?
6. Яагаад Иудейн удирдагч нар Есүсийг хүлээж аваагүй байхад зуутын дарга Түүнийг “зөвт хүн” байсан гэж хүлээн зөвшөөрсөн юм бол? Бид эндээс юуг сурч болох вэ?

## Хэрэгжүүлэх асуулт

Есүс загалмай дээр нас барах үедээ Бурханд итгэх агуу итгэлийг харуулсан. Түүний Бурханд итгэж байгаа итгэлээс бид ямар үлгэр дууриаллыг авч болох вэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэдний дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархал.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

## Үзэгдэл 56: “Есүсийг оршуулсан нь” Лук 23:50-56

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**
- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**
- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**
- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**
- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга
Есүсийг нас барсны дараа Иосеф гэдэг хүн Пилат руу очиж Есүсийн биеийг гуйж авдаг. Тэр хэдийгээр Есүсийг ялласан Иудейн зөвлөлийн гишүүн байсан ч зөвлөлийн шийдвэртэй санал зөрсөн аж. Сонирхолтой нь Иохан номд энэ үйл явдлын талаар бичсэн хэсэгт Иосефыг “нууцаар” Есүсийн шавь байсан гэжээ (Иохан 19:38-ыг үз). Харин Есүсийг нас барсны дараа тэр Пилат руу очиж Есүсийг оршуулах зөвшөөрөл гуйснаар эр зоригоо харуулжээ.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:
1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Иосефыг энд яаж дүрсэлсэн бэ? Тэр яагаад Иудейн зөвлөлийн Есүсийг яллах шийдвэртэй санал нийлээгүй гэж та бодож байна вэ?
3. Есүсийн цовдлогдохыг хараад Иосефийн сэтгэл ямар байсан бол?
4. Иосеф Есүсийн биеийг хаана аваачсан бэ? Тэр Есүсийн биеийг оршуулахад бэлдэж юу хийсэн бэ?
5. Есүсийг оршуулах үед хэн хамт байсан бэ? Тэдний талаар энд дурдсан нь ямар ач холбогдолтой вэ?
6. Та Есүсийг дагаж байсан эдгээр эмэгтэйчүүдийн нэг байсан бол таны сэтгэл ямар байх байсан бол?

## Хэрэгжүүлэх асуулт
Хэрэв хэн нэгэн Есүсийг “нууцаар дагадаг” бол ямар үйлдэл хийх вэ? /Ямар байх вэ?/
Танд Есүсийн “нууц дагалдагч” шиг байх уруу таталт тохиолдож байсан уу? Жишээ байвал хуваалцаарай.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт
- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал
- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархах.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Ням гарагын өглөө эрт булшин дээр ирсэн эмэгтэйчүүд Есүсийн биеийг анхилуун үнэртнээр тослох гэж Бямба garагт бүтэн өдөржин хүлээх ёстой байлаа. Учир нь тэр үед “Саббат” (Бямба гараг-Иудейчүүдийн мөргөл өргөдөг өдөр) өдөр ямар ч ажил хийж болдоггүй байжээ. Тэд бүтэн өдөржин хүлээх зуураа юу бодож байсан бол? Тэдний найдвар ингээд талаар өнгөрлөө гэж үү? Тэд бие биеэ зоригжуулах гэж оролдсон болов уу? Тэд Мессиа хэмээн итгэж байсан Есүст нь тохиолдсон зүйлсийн учрыг олох гэж оролдсон болов уу? Ням гарагын өглөө эрт булш руу алхаж явахдаа тэд юуны тухай бодож байсан бол?

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Эмэгтэйчүүд тэр Ням гарагын өглөө юу хийхээр төлөвлөж байсан гэж та бодож байна вэ?
3. Тэд булшин дээр очоод юуг олж мэдсэн бэ? Тэд дотогш ороод юу олсон бэ? Та тэдний оронд байсан бол үүнийг яаж хүлээж авах байсан бол?
4. Эмэгтэйчүүдийг гайхширч байх зуур хоёр тэнгэр элч гарч ирсэн. Эмэгтэйчүүд тэнгэр элчүүдийг хараад юу хийсэн бэ?
5. Тэнгэр элч нар Есүсийн талаар эмэгтэйчүүдэд юу хэлсэн бэ? Тэнгэр элчүүдийг үгийг сонсоод эмэгтэйчүүд юу хийсэн бэ?
6. Есүс дагалдагч нартаа Өөрийнхөө талаар үхээд дараа нь амилах болно гэж дахин дахин хэлж байсан. Гэхдээ эдгээр эмэгтэйчүүд өмнө нь үүнийг хараахан ойлгоогүй байсан бололтой. Тэд тэнгэр элчүүдтэй уулзсаны дараа юу өөрчлөгдсөн бэ?

## Хэрэгжүүлэх асуулт

Та анх Есүсийн амилалтын талаар сонсоод юу гэж бодож байснаа санаж байна уу? Энэ түүхийн хувьд та аль нэг хэсэгт нь итгэхэд бэрх санагдаж байсан уу? Танд одоо ч гэсэн итгэхэд хэцүү зүйл байдаг уу?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархал.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**
- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**
- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**
- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**
- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга
Есүсийн амилал бол дэлхийн түүхэн дэх хамгийн чухал үйл явдал гэдэг нь гарцаагүй юм. Хэрэв Есүс дахин амилаагүй бол тэр бусад хүмүүсээс нэг их ялгарахгүй байх байсан. Үнэндээ амилалт байгаагүй бол Есүсийг солиотой хүн гэж тооцохоор байв. Яагаад гэвэл тэр амьдралынхаа туршид дагалдагч нартаа Өөрийгөө үхээд амилах болно гэж үргэлж хэлдэг байсан бөгөөд мөн Өөрийгөө Бурханы хүү, хүн төрөлхтөний Аврагч хэмээн тунхагласан. Хэрэв Есүс амилаагүй бол Түүний хэлсэн бүхэн нь зүгээр л гаЛзуу хүний хоосон чалчсан үгс мэт байв. Харин Есүс үхлээс амилсан тул Тэр яг л тунхаглаж байсныхаа дагуу төгс Бурхан ба төгс хүн байсан гэдгээ ямар ч эргэлзэх зүйлгүй батлан харуулсан юм.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 4.** Ярилцах асуултууд:
1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүсийн булш хоосон байгааг харсан эмэгтэйчүүд хамгийн түрүүнд юу хийсэн бэ? Энэ үйлдлээс нь харвал тэдний сэтгэлд ямар мэдрэмж төрж байсан бол?
3. Эмэгтэйчүүдийн авчирсан мэдээг сонсоод шавь нар нь ямар хариу үзүүлсэн бэ? Тэд яагаад ийм хариу үзүүлсэн гэж та бодож байна вэ? Тэдний энэ хариу үйлдлийг хараад эмэгтэйчүүдийн сэтгэл ямар байсан бол?
4. Үнэндээ Есүс Өөрт нь юу тохиолдох талаар шавь нартаа олон удаа хэлж байсан. Тэд яагаад Түүнд итгээгүй гэж та бодож байна вэ?
5. Есүс эмэгтэйчүүдэд Өөрийнх нь амиллын талаар хамгийн түрүүнд олж мэдэх боломж олгосон нь сонирхолтой хэрэг. Энэ нь юуг илэрхийлж байна вэ?
6. Петр яагаад булш руу гүйж дотор нь орсон гэж та бодож байна вэ? Булш хоосон болсныг үзээд Петрийн толгойд нь ямар бодол эргэлдэж байсан бол?

## Хэрэгжүүлэх асуулт
Есүсийн амилалт таны хувьд ямар утга учиртай вэ? Энэ нь таны амьдралыг яаж өөрчилсөн бэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт
- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал
- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархх.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**
- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**
- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**
- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**
- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга

Бид эргэлзээний талаар өмнө нь ярилцсан. Энэ хэсэгт Есүс өрөөнд цугласан шавь нартаа үзэгдэж тэднийг айлгаж, цочоосон тухай гардаг. Есүсийг дахин хараад баярлах байх гэж бодмоор. Гэтэл тэд Түүнийг үнэхээр мөн эсэхэд эргэлзсэн. Мэдээж эргэлзэх шалтгаанууд байсан. Сүүлийн гурван өдөр тэд юу туулж өнгөрүүлснийг бодоод үз. Лукын бичсэнээр Есүс “Бичвэрийг ухааруулахын тулд тэдний оюун ухааныг нээсэн” (45 эш). Есүс тэдэнд Өөрийгөө дахин батлан харуулснаар эцэст нь тэд Түүнийг үнэхээр амьд байна гэдэгт итгэдэг.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүс тэдэнд харагдангуутаа хамгийн түрүүнд юу гэж хэлсэн бэ? Тэр яагаад ингэж хэлсэн гэж та бодож байна вэ?
3. Шавь нар нь эхэндээ Есүсийг хий үзэгдэл гэж бодсон хэмээн Лук бичжээ. Тэд яагаад ингэж бодсон байх гэж та бодож байна вэ?
4. Хэн ч чанга хэлээгүй боловч тэд Өөрийг нь хий үзэгдэл гэж бодож байгааг Есүс мэдэж байсан. Есүс тэдний юу бодож, мэдэрч байгааг мэдэж байсан. Энэ нь Түүний талаар юуг өгүүлж байна вэ?
5. Есүс тэдний айдас ба эргэлзээнд яаж хандсан бэ? Тэр үнэхээр амьд гэдгээ шавь нартаа батлахын тулд тэд нараар юу хийлгэсэн бэ?
6. Яагаад Есүс Мессиягийн талаарх бүх эш үзүүллэг Өөрөөр нь биелэгдсэн гэдгийг тайлбарлахын тулд Хуучин гэрээний бичвэрийг шавь нартаа сануулсан бэ? Энэ нь бидэнд Библийн ач холбогдол ба эрх мэдлийн талаар юуг зааж байна вэ?

## Хэрэгжүүлэх асуулт

Бидний амьдралд эргэлзээтэй үе ирэх үед хэрхэн даван туулах талаар энэ түүхээс юу сурч болох вэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд талархь.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга – Агуу захирамжийн биелэлтэд та хэрхэн хувь нэмрээ оруулах вэ?

{Бүлгийнхээ нэг гишүүний төрөлх хэлээр нь Матай 28:16-20-ыг уншуул.}

Есүс дагалдагч нартаа Сайн мэдээыг бусдад хүргэх тушаал өгсөн нь Агуу захирамж гэж нэрлэгдэх болжээ. Итгэгч хүн бүр Христийг бүх дэлхий даяар гэрчлэхэд хувь нэмрээ оруулах тушаал авсан. Бурхан бидний хүн тус бүрт Агуу захирамжийг биелүүлэхэд оролцох чухал үүргийг оноож өгсөн.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.
**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.
**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.
**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Есүс Агуу захирамжаар дагалдагч нартаа ямар тодорхой тушаалуудыг өгсөн бэ?
3. Энэ захирамж нь зөвхөн анхны дагалдагч нарт л хамаатай юу эсвэл бүх итгэгчдэд өгөгдсөн дуудлага уу? Яагаад?
4. Яагаад Есүс Өөрийг нь дагаж байгаа бидэнд хандан “тэнгэр газар дээрх бүх эрх мэдэл” Түүнд байгаа гэж хэлсэн бэ? Бид Христийн тухай бусдад ярьж, Сайн мэдээний шинэ бүлэг байгуулахаар оролдох үед энэ нь ямар ач холбогдолтой вэ?
5. Үйлс 1:8-9-ыг унш. (Энд Есүсийн Агуу захирамж ба дээш одсон тухай өөр нэг тэмдэглэл бичигдсэн.) Есүс яагаад шавь нараа Иерусалимаас эхэл гэж хэлсэн бэ? Энэ нь ямар чухал ач холбогдолтой вэ? Тэгээд Есүс тэднийг дараа нь юу хий гэж хэлсэн бэ?
6. Сая уншсан Үйлс 1-р бүлгийн багц хэсгээс харвал шавь нар сайнмэдээг хэнд хүргэх тушаал авсан бэ? Энэ нь Есүс бүх хүнийг хэрхэн хардаг талаар юуг өгүүлж байна вэ?
7. Манай улсад сайнмэдээ сонсох хэрэгтэй үндэстэн ястан байгаа юу?Тэдэн рүү ЯВЖ Есүсийн тухай ярьж өгөхийн тулд та юу хийх хэрэгтэй вэ?

Урагш харах

## Хэрэгжүүлэх асуулт

Агуу захирамжийг биелүүлэхэд та яаж хувь нэмрээ оруулах вэ? Нэгдүгээрт, та хувь хүнийхээ хувьд Христийг бүрэн дагаж, Ариун Сүнсээр дүүрэн байх хэрэгтэй. Хоёрдугаарт, Бурханаас таныг удирдан чиглүүлэхийг гуйж залбир. Гуравдугаарт, Бурхан таны залбиралд хариулах үед хаашаа ЯВахаа төлөвлө. Дөрөвдүгээрт, төлөвшсөн итгэгч нараас суралц. Тавдугаарт, санаачилгатай бай, ЯВ. Тантай хамт явж сайнмэдээг бусдад ярих итгэгч найзаа олоорой. Тэдгээр хүмүүст Есүс зайлшгүй хэрэгтэй.

## Хэрэгжүүлэлт

Өмнөх үзэгдлийнхтэй адилхан

## Залбирал

Өмнөх үзэгдлийнхтэй адилхан

Эргэж харах

**Бие биедээ санаа тавих**

- Бие биеийнхээ төлөө залбирна.
- Амьдралынхаа талаар ярьж хуваалцна (эрүүл мэндийн асуудлууд, гэр бүл, санхүүгийн байдал, сүнслэг хэрэгцээ, спорт ... гэх мэт.)

**Хамтдаа баярлах**

- Дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр

**Бүлэгтээ болон бие биедээ алсын хараагаа сануулах цаг**

- Бид Есүсийн илүү сайн дагалдагч болно
- Манай нийгэм хамт олон Бурхан руу илүү ойртох болно

**Өгөх ба хуваалцах**

- Бусдад туслаарай гэж Бурханы танд өгсөн зүйлсээс ямар нэг бодитой мэдэгдэхүйц зүйлийг бусдадаа өгч хуваалцаарай..

Дээш харах

## Танилцуулга - Та Христэд итгэгч болсон гэдэгтээ яаж бат итгэлтэй байх вэ

*“Учир нь би хүлээн авснаа та нарт юуны түрүүнд дамжуулсан. Бичвэрийн дагуу Христ бидний нүглийн учир үхсэн бөгөөд 4оршуулагдан, Бичвэрийн дагуу гурав дахь өдөртөө амилуулагдсан агаад...” 1 Коринт 15:3-4*

Есүсийг энэ дэлхий дээр амьдарснаас хойш зуун зууны туршид сая сая хүмүүс Христийг амьдралдаа урин оруулсаар ирсэн. Гэхдээ олон хүн авралдаа бат итгэлгүй байснаасаа болоод үүнийг дахин дахин хийх нь бий. Тэд Христийн оршихуй тэдэнтэй хамт байгаа гэдэгт бүрэн итгэлгүй, хэрэв өнөөдөр үхвэл Эзэнтэй хамт байхаар мөнхийн улс руу явна гэдэгтээ итгэлгүй байдаг. Та аврагдсан гэдэгтээ бат итгэлтэй байна уу? Христэд итгэх шийдвэр нь оюун ухаан, сэтгэл хөдлөл болон хүсэл тэмүүллийг бүгдийг нь хамруулдаг гэдгийг мэдэх хэрэгтэй.

**Алхам 1.** Үзэгдлийг хоёр удаа үз.

Энэ кодыг уншуулаад киноныхоо энэ үзэгдлийг гар утсан дээрээ үзээрэй. ЕСҮС киноны цахим хуудаснаас киног өөр хэл дээр үзэж болно.

**Алхам 2.** Бүлгийн аль нэг гишүүнийг үзэгдэлд гарсан түүхийг өөрийн үгээр илэрхийлж хэлэхийг хүс.

**Алхам 3.** Бүлгийн гишүүдэд үзэгдэл дээр дурдагдаагүй хэсгүүдийг болон залруулах зүйлсийг нээлттэй ярилцах боломж олго.

**Алхам 4.** Ярилцах асуултууд:

1. Энэ түүхээс юу нь танд хамгийн их таалагдсан бэ? Таны анхаарлыг юу илүү их татсан бэ?
2. Таны хувьд “гэм” гэдэг үг ямар утгатай вэ? Есүс таны гэмийн төлөөсийг төлөхийн тулд юу хийсэн бэ?
3. Христэд итгэдэг амьдрал бол сэтгэл хөдлөлийн дагуу бус итгэлийн дагуу амьдардаг. Таны итгэлийн амьдралд сэтгэл хөдлөл ямар үүрэгтэй вэ?
4. Ямар үед сэтгэл хөдлөлөө дагах нь буруу үр дүнд хүргэж болзошгүй вэ?
5. Аврагдсан гэдэгтээ бат итгэлтэй байх нь яагаад чухал гэж та бодож байна вэ?
6. Та яаж Есүст итгэсэн тухайгаа бүлгийнхэндээ хуваалцаарай.

Урагш харах

## Хэрэгжүүлэлт

- Бурхан танаас ямар хариу хүсэж байгаа талаар өөрийн бодлыг бүлгийнхэндээ хуваалцаарай.
- Түүхийг бие биедээ ярьж (2 дахь алхам шиг) бататгаарай.
- Өнөөдрийн үзсэн түүхийг бусдад ярьж өгөн тэднийг дараагийн бүлгийн уулзалтад ирэхийг уриарай.

## Залбирал

- Өнөөдөр сурсан зүйлсийнхээ төлөө Бурханд таларх.
- Өөрийн нийгмийн хүрээлэл дэх бусад хүмүүсийн төлөө залбир.
- Бүлэг дотроо бие биеийнхээ төлөө залбир.

## Дүгнэлт

Та Христэд итгэгч болсон гэдэгтээ бат итгэлтэй байхын тулд ойлгосон байх шаардлагатай дөрвөн чухал үнэн бий. Үүнд:

1. Бурхан танд хайртай бөгөөд таны амьдралд хандсан гайхалтай төлөвлөгөө Түүнд бий.
2. Бид нүгэлтэй бөгөөд Бурханаас тусгаарлагдсан байсан. Тийм учраас бид Есүс Христгүйгээр Түүний хайр ба бидний амьдралд хандсан төлөвлөгөөг нь эдэлж чадахгүй.
3. Есүс Христ бол хүн төрөлхтөнийг гэмээс чөлөөлөхөөр Бурханы хангаж өгсөн цорын ганц зам юм. Зөвхөн Түүгээр дамжуулан бид Бурхантай хувьчилан уулзаж, Түүний хайрыг эдлэн амьдарч чадна.
4. Бид хувь хүнийхээ хувьд Есүс Христийг Аврагчаа болгон хүлээж авах ёстой. Тэгвэл бид Бурханыг хувьчилан таньж мэдээд зогсохгүй Түүний хайрыг амсаж мэдрэх болно.

Энэ үзэгдлийг дахиад нэг удаа үзээрэй. Хэрэв та аврагдсан гэдэгтээ итгэлтэй биш байгаа бол энэ удаад үүнийг дахин үзэхдээ Есүсийг хүлээн авахын төлөө итгэлтэйгээр залбираарай. Хэрэв та Есүс Христийг Аврагч Эзэнээр хүлээгээд авчихсан бол Түүний Үгэн дээрх амлалтуудад үндэслэн Христэд итгэгч болсон гэдэгтээ итгэлтэй байж болно.



# ЕСҮСИЙГ МЭДЭХ НЬ

Жижиг бүлэг ба Сайнмэдээ тараахад зориулсан гарын авлага